

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭРЧ  
БАТЛАВ  
Б.АЗЗАЯА

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
ЛАБОРАТОРИ 2 ДУГААР СУРГУУЛЬ



2024 оны 2 дүгээр сарын 19-ны өдөр

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
ЛАБОРАТОРИ 2 ДУГААР СУРГУУЛЬД ҮДИЙН ЦАЙ НИЙЛҮҮЛЭХ  
ГҮЙЦЭТГЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын иэр: Дорноговь сайншианд сумын ерөнхий боловсролын  
лаборатори 2-р сургуульд үдийн хоол нийлүүлэгчийг сонгон шалгаруулах  
Тендер шалгаруулалтын дугаар:

Дорноговь аймаг

2024 он

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2024.02.19

1. *Дорноговь аймгийн Сайншианд сумын өронхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Дорноговь аймгийн Сайншианд сумын өронхий боловсролын лаборатори 2 дугаар сургуульд үдийн хоол нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.*
2. Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.
3. Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөгөөр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаас худалдан авна.
4. Үнийн саналыг **2024.03.22-ны өдрийн 12 цаг 30 минут-аас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар** ирүүлнэ.
5. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024.03.22-ны өдрийн 13 цаг 00 минут-д** нээнэ.
6. Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендертэй холбоотой мэдээллийг доорх хаягаар дотрууулж болно.

*Дорноговь аймгийн Сайншианд сумын өронхий боловсролын  
лаборатори 2 дугаар сургуулийн лаборатори.  
Холбоо барих утас: 70523668*

**Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

2024.02.19

1. *Дорноговь аймгийн Сайншанд сумын өронхий боловсролын лаборатори 2 дугаар сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Дорноговь аймгийн Сайншанд сумын өронхий боловсролын лаборатори 2 дугаар сургуулийн удийн хоол нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.*
2. Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.
3. Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50000 төгрөгөөр [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаас худалдан авна.
4. Үнийн саналыг **2024.03.22-ны өдрийн 12 цаг 30 минут-аас өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаалгаар** ирүүлнэ.
5. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024.03.22-ны өдрийн 13 цаг 00 минут-д** нээнэ.
6. Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендертэй холбоотой мэдээллийг доорх хаягаар дотруулж болно.

*Дорноговь аймгийн Сайншанд сумын өронхий боловсролын  
лаборатори 2 дугаар сургуулийн лаборатори.  
Холбоо барих утас: 70523668*

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |  |   |
|--|---|
| <p><b>1. Эрх бүхий тендерт оролцогч</b></p>      | <p>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</p>  |
| <p><b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b></p> | <p>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</p> <p>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</p>   |
| <p><b>3. Тендерийн иж бүрдэл</b></p>             | <p>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлсээс бүрдэнэ.<br/>Иргэдийн бүлэг бол дараах материалыг бүрдүүлэн оролцно. Үүнд:<br/><br/>a) Хамтран ажиллах гэрээ<br/>b) Гэрээний маягт<br/>c) Чадварын тухай мэдээлэл маягтын дагуу<br/>d) Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь<br/>e) Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт<br/>f) Техникийн тодорхойлолт<br/>g) Үнийн санал</p> <p>ААН байгууллага бол дараах материалыудыг бүрдүүлнэ.</p> <p>Үүнд:</p> <ol style="list-style-type: none"><li>1. Үнийн санал</li><li>2. Компани танилцуулага</li><li>3. Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь</li><li>4. Чадварын мэдээлэл/Санхүүгийн тайлан сүүлийн 2 жил / болон бусад баримт бичиг</li><li>5. Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар/гадаад худалдаа/</li><li>6. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li><li>7. Харилцагч банкны тодорхойлолт /Өргүй байх/</li><li>8. Татварын газрын тодорхойлолт /Өргүй байх/</li><li>9. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /Өргүй байх / Э</li><li>10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /Өргүй байх /</li><li>11. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж</li><li>12. Бараа бүтээгдэхүүний танилцуулага болон фото зураг, техникийн тодохойлолтын хамт/ тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс ажлын 5 хоногийн өмнөх хоногоос дотогш байна/</li></ol> |
| <p><b>4. Тендерийн үнэ</b></p>                   | <p>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</p>   |

- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
- 5.1 Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
- 5.2 Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлэнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1 Үнийн санал хүчинтэй байх хугацаа 30 хоног.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.
- 8.2. Бусад оролцогчдод тэдгээрийн шалгараагүй үндэслэлийг тодорхой тайлбарласан мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлнэ.

**Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Тендерт оролцогч нь дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Унийн санал /Унийн санал болон нийлүүлэлт, ажлын хуваары/</li> <li>2. Компаний танилцуулага</li> <li>3. Үндсэн үйл ажиллагааны чиглэл нь нийтийн хоол болон хоол үйлдвэрлэлийн зөвшөөрөлтэй байх</li> <li>4. Ур чадварын мэдээлэл /ажилчдын мэдээлэл, багаж хэрэгслийг зурагжуулан баталгаажуулсан байх /</li> <li>5. Компанийн ажилчид зохих журмын дагуу эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамрагдсан байх /цагаан дэвтэр хавсаргах/</li> <li>6. Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар</li> <li>7. Тухайн бараа ажил үйлчилгээ нийлүүлэхэд хүнсний үйлдвэр үйлчилгээ явуулах зөвшөөрөлтэй, аймгийн Мэргэжлийн Хяналтын Газрын дүгнэлт</li> <li>8. Мэргэжлийн Хяналтын Газраас ажлын байрны эрдээлийн үнэлгээ хийлгэсэн байх</li> <li>9. Тоног төхөөрөмжийн хүчин чадлыг тооцож хоногт гарах бүтээгдэхүүний тоо, тоног төхөөрөмжүүдийн жагсаалтыг зургийн хамт ирүүлэх /Техник ашиглалтын карт, фото зураг/</li> <li>10. Нэгж бүтээгдэхүүний үндсэн шимт бодис тооцсон Мэргэжлийн Хяналтын Газрын дүгнэлт</li> <li>11. Нийлүүлэх үйдийн хоолны цэс, технологийн карт ирүүлэх</li> <li>12. Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</li> <li>13. Харилцагч банкны тодорхойлолт /Өргүй байх/</li> <li>14. Татварын газрын тодорхойлолт /Өргүй байх/</li> <li>15. Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /Өргүй байх/</li> <li>16. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /Өргүй байх/</li> </ol> <p>Сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр төлбөртэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолгоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <ol style="list-style-type: none"> <li>17. Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан / 2022, 2023 он/ /аудитын дүгнэлтийн хамт/;</li> <li>18. Бараа бүтээгдэхүүний танилцуулага, фото зураг, техникийн тодорхойлолтыг тендер зарлагдсан өдрөөс хойш авч баталгаажуулсан байна.</li> <li>19. Санал болгож буй барааны нийлүүлэлтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтиар баталгаажуулж тендерт</li> </ol>

ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

Тухайн барааг нийлүүлэхэд шаардлагатай мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн туршлагыг дараах хүснэгтээр ирүүлнэ. Үүнд:

Үдийн хоол боловсруулах ажлын байр түрээсийн байж болно.

Албан тушаал	Мэргэжил	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо
Тогооч	Тогооч	1	3-аас доошгүй жил
Туслах тогооч	Тогооч	1	
Бэлтгэгч	Мэргэжил харгалзахгүй		

Дээрх хүснэгтэд заасан мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн үнэмлэх, эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдсаныг нотлох дэвтэр баримт бичгийг ирүүлнэ. Дээрх нэмэлт материалындаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг, нотлох баримт ирүүлээгүй эсвэл шаардлага хангагүй, баталгаажуулаагүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.

Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1

БШУЯ, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2020 оны 12 сарын 02-ны өдрийн А/166, А/559, 222 дугаар тушаалаар батлагдсан “Норматив батлах тухай”-г баримтлах

- Хоолны газар нь үйлдвэрлэл, үйлчилгээний технологи, хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, ариун цэврийн шаардлагыг хангасан байна.
- Хоолны газрын агаар сэлгэлтийн системийг гол тогоонд ялгаруулж буй хоолны үнэр, утаа, уурыг үйлчилгээний танхимд тархахгүй байх нөхцлийг бүрдүүлж, бусад өрөө, тасалгааны талбайн хэмжээ онцлогос хамаарч агаар сэлгэлтийн системийн хучин чадлыг тооцож суурилуулсан байна.
- Хоолны газарт суурилуулсан агаар сэлгэлтийн системийн дуу нь 67 децибаллаас дээшгүй байна.
- Хоол үйлдвэрлэлийн өрөөний шал, хана, таазыг ус нэвтэрдэггүй бат бөх, тэгш гөлгөр гадаргуутай, ёнгө үзэмж сайтай цэвэрлэхэд хялбар, засаж сэлбэх боломжтой материалыар хийж, хортон шавьж, бичил биетэн үржихээс хамгаалсан байна.
- Хоолны газар нь хэрэглэгчдэд зориулсан гар угаах, хатаах төхөөрөмж бүхий бие засах газар, хувцасны өлгүүр, гутал арчигч зэргийг байрлуулсан байна.
- Хоолны газар нь ажилтны амралтын болон хувцас солих өрөө, гадуур хувцас, цүнх зэрэг хувийн эд зүйлсийг хадгалах зориулалтын шүүгээтэй байна.

	<p>7. Хоолны газарт гол түймэр унтраах хэрэгслүүлдийг байрлуулсан байна.</p> <p>8. Техник, тоног төхөөрөмж нь цахилгааны болон галын аюулгүйн техник ашиглалтын дүрмийн шаардлагыг бүрэн хангасан байна.</p> <p>9. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газар нь бэлэн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг гадны бохирдоос хамгаалсан хатуу хучилттай талбай дээр байрлуулж, хог хаягдлын цэгээс 100 метрээс багагүй зайдай байга.</p> <p>10. Явуулын үйлчилгээтэй түргэн хоолны газар нь хагас боловсруулсан болон бэлэн халуун, хүйтэх хоол, бүтээгдэхүүн хадгалах зориулалтын хоол халуун байлгагч, хөргөх төхөөрөмжөөр хангагдсан, нэг хэрэглээний сав, хэрэгсэл хадгалах зориулалтын шүүгээтэй байна.</p>	
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим сайтаар</p> <p>Огноо: 2024 оны 3 дугаар сарын 22-ны өдөр</p> <p>Цаг: 12 цаг 30 минут</p>	
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Сайншанд сумын ЕБ-ын лаборатори 2 дугаар сургууль</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 3 давхар 317 тоот ороо</p> <p>Аймаг хот: Дорноговь аймаг, Сайншанд сум</p> <p>Улс: Монгол Улс</p> <p>Огноо: 2024 оны 3 дугаар сарын 22 -ны өдөр</p> <p>Цаг: 13 цаг 00 минут</p>	
ТОӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ:</p> <p><i>Байхгүй</i></p>	

## Дөрөв. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| 1. Гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээ       | 1.1. Гүйцэтгэгч барааг гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.   |
| 2. Ажлын хуваарь                          | 2.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөл буюу техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт заасан хуваарийг чанд мөрдөж ажиллана.  |
| 3. Оюуны өмчийн эрх                       | 3.1. Гэрээнд заагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаанд оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| 4. Гэрээнд өөрчлөлт оруулах               | 4.1. Гэрээний дагуу худалдан авах барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 5. Гүйцэтгэлийн хянаагч                   | 5.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий захиалгчийг төлөөлнө гүйцэтгэлийг хянаагч ажиллана.  |
| 6. Төлбөр                                 | 6.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 7. Алданги оногдуулах                     | 7.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.   |
| 8. Үүргээ биелүүлээгүй гээс гэрээг цуцлах | 8.1. Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 9. Маргааныг шийдвэрлэх                   | 9.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиркоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |
| 10. Бусад нөхцөл                          | 10.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаатай байна.<br>10.2. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Дарис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.<br>10.3. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна. |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>  |  |
| 11. Үйл ажиллагааны хотолбор              | 11.1. Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэлийн хянаагчид хүргүүлж батлуулна.   |

- |  |   |
|--|---|
| <b>12. Зөрчил,<br/>гологдол<br/>иlрүүлэх</b>           | 12.1. Гүйцэтгэлийн хянагч гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар мэдэгднэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэлийн хянагч нь гүйцэтгэж буй аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах эрхтэй.   |
| <b>13. Зөрчил<br/>гологдол<br/>арилгах</b>             | 13.1. Гүйцэтгэлийн хянагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.<br>13.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| <b>14. Зөрчил<br/>гологдол<br/>арилгахгүй<br/>байх</b> | 14.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол Гүйцэтгэлийн хянагч зөрчил, гологдол арилгахаад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.  |
| <b>В. ГЭРЭЭГ ДУУСГАХ</b>                               |   |
| <b>15. Гэрээний<br/>үүрэг<br/>дуусгавар<br/>болох</b>  | 15.1. Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хэрэгжүүлж дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг гүйцэтгэлийн хянагчид хүргүүлэх бөгөөд гүйэтгэлийн хянагч ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана.  |

**Тав. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: <i>[Санал авах урилгад заасан нэр болон дугаар]</i>
<b>ГЕН 2.1</b>	Гэрээ хэрэгжүүлж эхлэх өдөр:  Гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдөр:
<b>ГЕН 3.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 4.1</b>	Гүйцэтгэгч дараахь баримт бичгийг захиалагчид бүрдүүлж өгнө. Үүнд: <i>[Жагсааж бичих] Тухайлбал:</i> 1) <i>Нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт унийг заасан нэхэмжлэхийн хувь;</i> 2) <i>Барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн барийнт:</i> 3) <i>Үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ:</i> 4) <i>Үйлдвэрлийн эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ:</i> 5) <i>Барааны гарал үүслийн гэрчилгээ:</i> 6) <i>Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага</i> 7) <i>Гүйцэтгэлийн зураг гэхмэл</i>
<b>ГЕН 5.1</b>	Чанарын баталгаат хугацаа эсхүл баталгаат засварын хугацаа <b>1 жилийн</b> ба түүнээс дээш байна.
<b>ГЕН 6.1</b>	Алданги ногдуулах хэмжээ гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн <b>0,5 хувь</b> байна. <sup>1</sup>  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн <b>10 хуртэл хувь</b> байна.

Зургаа. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Техникийн тодорхойлолтын хураангуй Нийлүүлэгдэх бараа болон хөлбөгдох үйчилгээ нь дурьдсан техникийн тодорхойлолт, стандарт нийцсэн байна.



Нэр төрлийн дугаар	Хоолны нэр	Техникийн тодорхойлолт
Шингэн бүтээгдэхүүн	Үзэм хүрэн манжингийн шүүс	<p><b>Барааны нэр: Үзэм хүрэн манжингийн шүүс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Монгол аргаар бэлтгэсэн стандартын шаардлага хангасан байна. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо, орц, хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.</li> <li>-Хэт иsgэлэн, гашуун ахарсан, амт муутай, хэт их чихэрлэг биш байна.</li> <li>-Шаардлагатай илчлэг чанар, килкалорийг агуулсан, амин дэмээр баялаг, ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.</li> <li>-Зориулалтын саваар тээвэрлэнэ. Шинжилгээний болон гарал үүслийн бичигтэй бүтээгдэхүүнээр хийсэн байна.</li> <li>-Дагалдах бичиг баримтад тогоочийн нэр, тоо хэмжээ, унэ зэргийг тусгасан байна.</li> </ul>
	Аньсны жүүс	<p><b>Барааны нэр: Аньсны жүүс</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Монгол аргаар бэлтгэсэн стандартын шаардлага хангасан байна. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо, орц, хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.</li> <li>Хэт иsgэлэн, гашуун ахарсан, амт муутай, хэт чихэрлэг биш байна.</li> <li>-Шаардлагатай илчлэг чанар, килкалорийг агуулсан, амин дэмээр баялаг, ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэсэн байна.</li> </ul>
	Буцалгасан аарц	<p><b>Барааны нэр: Буцалгасан аарц</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Эрүүл ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.</li> <li>-Гадны үнэр амт байхгүй, тослог стандарт Монгол аргаар бэлтгэсэн стандартын шаардлага хангасан байна. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо, орц, хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.</li> <li>Хэт иsgэлэн, гашуун ахарсан, амт муутай, хэт чихэрлэг биш байна.</li> <li>-Шаардлагатай илчлэг чанар, килкалорийг агуулсан, амин дэмээр баялаг, ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэсэн байна</li> </ul>
	Хярам	<p><b>Барааны нэр: Хярам</b></p> <ul style="list-style-type: none"> <li>-Стандартын шаардлага хангасан монгол аргаар боловсруулсан бүтээгдэхүүн байна.</li> <li>-Зориулалтын сав баглаанд савласан байна.</li> <li>-Эрүүл ахуйн шаардлага хангасан байна.</li> <li>-Элдэв, амт үнэргүй байна.</li> </ul>

		<p>-Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.</p>
	Чацраганы жүүс	<p><b>Барааны нэр: Чацраганы жүүс</b>  -Монгол аргаар бэлтгэсэн стандартын шаардлага хангасан байна. Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо, орц, хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.  Хэт исгэлэн,гашуун ахарсан,амт муутай,хэт чихэрлэг биш байна.  -Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.</p>
	Холимог будаатай хуурга	<p><b>Барааны нэр: Холимог будаатай хуурга</b>  -Эрүү ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.  -Гадны үнэр амт байхгүй,стандарт түвшинд байх,шинэ байна.  -Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо,орц,хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.  -Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.  \ Огурцы,помидори хачиртай\</p>
	Ногоотой гоймонтой хуурга	<p><b>Барааны нэр: Ногоотой гоймонтой хуурга</b>  -Эрүү ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.  -Гадны үнэр амт байхгүй,стандарт түвшинд байх,шинэ байна.  -Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо,орц,хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.  -Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.  \Алаг салатны хачиртай\</p>
	Агшаасан цагаан будаа	<p><b>Барааны нэр: Агшаасан цагаан будаа</b>  Эрүү ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.  -Гадны үнэр амт байхгүй,стандарт түвшинд байх,шинэ байна.  -Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо,орц,хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.  -Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна.  \ааруул,ээзгийний хольцтой\</p>
	Мантуун бууз	<p><b>Барааны нэр: мантуун бууз</b>  Эрүү ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.  -Гадны үнэр амт байхгүй,стандарт түвшинд байх,шинэ байна.</p>

		<p>-Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо,орц,хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.</p> <p>-Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна \ лууван,байцааны хачиртай\</p>
	Тефтель	<p><b>Барааны иэр: Тевтель</b> Эрүү ахуйн шаардлага хангасан саванд савлагдсан байна.</p> <p>-Гадны үнэр амт байхгүй,стандарт түвшинд байх,шинэ байна.</p> <p>-Бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн огноо,орц,хаана үйлдвэрлэсэн тухай тусгасан байна.</p> <p>-Шаардлагатай илчлэг чанар,килкалорийг агуулсан,амин дэмээр баялаг,ариун цэврийн шаардлагыг хангасан нөхцөлд үйлдвэрлэгдсэн байна. \ Улаан манжингийн хачиртай\</p>

Баглаа боодол:


Хоол хоолон бүтээгдэхүүнийг зориулалтын таглаатай ариутгасан саванд ба тослогийн стандарт хангасан байна.

Техникийн тодорхойлолт

Барааны тодорхойлолт:\Барааны тодорхойлолт,техникийн үзүүлэлтийг энд бичнэ\

Стандарт: Захиалагч холбогдох стандартыг заана. Эсвэл \тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартад хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.\ гэж бичнэ.,

Бүтээгдэхүүнд зөвхөн нэг үнэ ирүүлэх бөгөөд гэрээний хэрэгжилтийн хугацаанд үнэ тогтвортой байна.

Боловсруулсан:  У.Огтонцэг

**Долоо. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

Нэр	Тодорхойлолт	Хүчинчилж хийжүүлэх	Тоо шинжлэх желжилтийн услугийн хаалгын төслийн хувь	Инкотермиин нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа	Инкотермиин нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын лаборатори 2 дугаар сургуульд Удийн хоол нийлүүлэх гүйцэтгэгчийн сонгон шалгаруулах ажил							

**Найм. ЖИШИГ МАЯГТ**

**ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг, [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр терөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувь хамарагчай.

№	Гэрээний нэр	Захиалагч холбоо барих хаяг/ утас факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1					
2					
3					
4					
5					
Бусад					

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

### ЗАХИАЛАГЧ

### ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг: \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг ;
- Үнийн санал
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;

- f. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлтийн хуваарь;
- g. Санхүүжилтийн хуваарь;

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн нэд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ..

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]